

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Өчигдөр манай Нээлттэй Хаалганы Өдөрлөгт хүрэлцэн ирсэн эцэг эхчүүдээ ОУДС-ийн нийт хамт олон бид талархал илэрхийлж байна. Сурагчдын боловсрол тэдний сайн сайхны төлөө та бүхэнтэй хамтран ажиллах нь бидэнд их чухал байдаг. Өчигдрийн арга хэмжээг бид эцэг эхчүүд та бүхэнд зориулж хийсэн бөгөөд энэ үеэр та бүхэн хүүхдийнхээ багш нартай уулзаж энэ жил судлах хөтөлбөрийн талаар мэдээлэл авах боломжтой байсан. Хэрвээ та нар манай арга хэмжээнд ирж амжаагүй бол бид та бүхний асуултанд хариулахад байнга бэлэн байх болно. Бид нартай уулзаж ярилцах нь чухал гэж үзэж байгаа бол та бүхэн утсаар болон электрон шуудангаар бидэнтэй холбогдож болно. Сургууль гэр бүлийн хоорондын харилцааны хамгийн анхны алхам нь юуны түрүүнд анги удирдсан багш нартай эцэг эхчүүд та бүхэн холбоо барих явдал юм.

Манай стратеги төлөвлөгөөний дагуу энэ жил бид эцэг эхчүүдтэй харилцах харилцаагаа улам сайжруулах болно. Бид та бүхэнтэй электрон шуудан, сургуулийн Мэдээ, сурагчдын сурлагын дүн, мэдээлэл өгөх уулзалтууд зэргээр дамжуулан холбоо барьж зөвлөлдөж байх болно. Жишээ нь бид энэ жил Монгол, Солонгос эцэг эхчүүдтэй тусад нь уулзалт хийж төрөлх хэл дээр нь мэдээлэл өгөх болно. Эхний уулзалт 9 сарын 15-ны Пүрэв гарагт сургууль дээр 18:30-д болно.

Стратеги төлөвлөгөөний дагуу бидний анхаарч ажиллах өөр нэг чиглэл бол аюулгүй байдал, хамгаалалтын асуудал байх болно. Бид Галын бэлэн байдлыг шалгасан анхны түргэн жагсаалыг энэ долоо хоногийн Лхагва гарагт явуулсан. Энэ арга хэмжээг сурагчид нухацтай хүлээн авч эмх цэгцтэй, чимээгүй, журамтай байж бэлэн байдалд жагслаа. Бид цаашид сайжруулах хэд хэдэн зүйлийг анхаарч авсан бөгөөд удахгүй галын бэлэн байдлыг шалгах ажиллагааг дахин явуулах болно.

Өглөөд сурагчдыг хүргэж ирж байгаа автобус, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг би ажиглаж байгаа. Ерөнхийдөө манай жижүүрүүд замын хөдөлгөөнийг чиглүүлэн, жолооч та бүхний хамтын хүчээр би энэ асуудлыг аюулгүй гэж дүгнэсэн. Гэхдээ хэд хэдэн жолооч замын хөдөлгөөн дунд зогсож сурагчдыг буулган арын машинууд нь зогссон машиныг тойрч гарах гэж ухарч байгааг харсан. Энэ байдлаас болж аваар осол гарах магадлалтай.

Сурагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс та бүхэн тогтмол өглөөд болон өдөр хичээл тарахад машины зогсоолд машинаа зөв байрлуулсаны дараа сурагчдыг машинаасаа буулгаж эсвэл машинд суулгасаны дараа хойшоо чиглэлийн дагуу машины зогсоолоос гарч шинээр тавигдсан 4 урсгалтай замаар тойрч явахыг анхааруулж байна.

ОУДС- дээр бид зөвшөөрөлгүй хүмүүс сургуулийн байрлуу орохоос сэргийлэх талаар бас анхаарч ажиллаж байна. Өглөө хичээл орох, өдөр хичээл тарахаас бусад үед сургууль руу ирсэн бүх эцэг эхчүүд, бусад зочид гадаа харуулын байранд бүртгүүлж дотогш орж ирээд үүдний ресепшинд давхар бүртгүүлж байхыг бид шаардаж байгаа.

Бид цаашид аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээнүүдийг та бүхэнд мэдээлэх болно. Аюулгүй байдлын талаар ярьж байгаа боломжийг ашиглан та бүхэнд хандаж хэрвээ том хүүхдүүд чинь хот дотор насанд хүрэгсэдтэй цуг яваагүй бол заавал

нэг найзтайгаа хамт явж, гар утсаа үргэлж биедээ байлгаж, эрсдэлтэй байдал тулгарвал юу хийхээ мэдэж байх ёстойг зөвлөө. Энэ зөвлөгөө бид бүхэнд бүгдэд нь хамааралтай.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

9 сарын 13-ны Мягмар гараг	12-р ангийн сурагчдын эцэг эхэд коллежийн мэдээлэл өгөх уулзалт- 18:30-20:00 Номын Санд
9 сарын 15-ны Пүрэв гараг	Монгол, Солонгос эцэг эхчүүдэд ОУДС-ийн талаар мэдээлэл өгөх уулзалт 18:30
9 сарын 17-ны Бямба гараг	ОУДС-ийн Намрын Баяр 11:00-14:00
9 сарын 23-ны Баасан гараг	Фото Зургийн өдөр

МОНГОЛ, СОЛОНГОС ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД МЭДЭЭЛЭЛ ХИЙХ УУЛЗАЛТ

Та бүхэн хичээлийн шинэ жилийг амжилттай угтсан гэдэгт би итгэлтэй байна. Бид та бүхэнтэй хамтран ажиллаж байгаадаа баяртай байна. Бид Монгол, Солонгос хэл дээр мэдээлэл хийх уулзалтанд Монгол, Солонгос эцэг эхчүүд та бүхнийг урьж байна. Энэ уулзалт 9 сарын 15-ны 18:30-д болно. Та бүхэн энэ өдрийг хуанлидаа тэмдэглээрэй. Уулзалт 2 тусдаа өрөөнд болно. Монгол эцэг эхчүүдэд Дэд Захирал Туул Арилдий мэдээлэл хийж Солонгос эцэг эхчүүдэд Mr. Choi багш мэдээлэл хийнэ.

Та бүхний төрөлх хэл дээр мэдээлэл хийх энэ уулзалтанд Монгол, Солонгос эцэг эхчүүд та бүхнийг ирж оролцохыг урьж байна. Энэ уулзалтанд оролцоноор та бүхэн сургуулийн талаар болон хүүхдийнхээ сургалтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

Та бүхэнтэй энэ арга хэмжээний үеэр уулзана гэж найдаж байна.

Дэд Захирал Арилдийн Туул

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өнгөрсөн долоо хоногт дунд сургуулийн кемп аялалууд амжилттай болж өнгөрлөө. Энэ үеэр цаг агаар маш тааламжтай байсан бөгөөд нэлээд олон хүн наранд борлож ирлээ. 6-12-р ангийн сурагчид Бүүвэйт, Тэнгэрийн Элч, Хустайн нурууны кемпэд аялал зохион байгуулсан. Кемп аялалыг төлөвлөж зохион байгуулан сайн ажилласан багш нартаа дахин баяр хүргэе.

Дунд сургуулийн сурагчдын зөвлөл гишүүдээ бүрдүүлж ажиллаж эхэллээ. Тэд сурагчдад зориулж олон төрлийн сонирхолтой арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Та бүхэн тэдний санал санаачлага, үйл ажиллагааг дэмжиж ажиллаарай. Бид сурагчдаа баяр хөөртэй идэвх оролцоо сайтай байхыг хүсдэг. Дунд сургуулийн сурагчдын зөвлөлийн зөвлөх багш Ms. Astrid Richard Cook, Ms. Karen Bailey Summers нарт баяр хүргэе. Тэд хоюулаа сурагчдад тусалж зөвлөж ажиллахад бэлэн байгаа.

Сурагчдын дугуйлангууд хичээллэж эхэллээ. Та бүхэн хүүхдийнхээ хуваарьтай сайтар танилцаж гэртээ харих цагийн хуваарийг нь мэдэж аваарай. Дунд ангийн сурагчид болон ахлах ангийн сурагчдын дунд залуу аялагчдын клубын дугуйлан ажиллана. 10 сард болох волейболын тэмцээнд оролцох охид хөвгүүдийн баг тамирчид бэлтгэлдээ гарч хичээлийн дараа 4 цагаас болон хичээл эхлэхээс өмнө бэлтгэлээ хийж байна. Та бүхэн хүүхдүүдээ энэ багт орохыг дэмжээрэй.

Та бүхэнд ямар нэгэн асуулт, санал хүсэлт байвал надтай болон сургуулийн ресепшинтэй холбоо бариарай. Пүрэв гарагт болсон Нээлттэй Хаалганы Өдөрлөгийн үеэр та бүхэнтэй уулзсандаа баяртай байна. Бид та нартай хамтран ажиллаж сурагчиддаа амжилттай сайн суралцахад нь тусалж байгаа нь бидний гол зорилго билээ.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Нээлттэй Хаалганы Өдөрлөг дээр та бүхэнтэй уулзсандаа баяртай байна. Та бүхэн хүүхдийнхээ сургалтын талаар болон багш нартай хэрхэн харилцах, хүүхэддээ гэрт нь хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар мэдэж авах нь сургалтын гол чухал хэсэг байдаг.

Хэрвээ хүүхэд тань хичээлийн цагаар ямар нэгэн эм уух хэрэгтэй бол та бүхэн ангийн багшид нь хүүхдэд тань эмийг ямар хэмжээтэйгээр хэдэн цагт өгөх зааврыг эм уулгах зөвшөөрлийн хамт бичиж ирүүлнэ үү.

Амралтын өдрүүдээ ая тухтай өнгөрүүлээрэй.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya